**МОНГОЛ УЛС**
**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2022 оны 03 сарын 25 өдөр Дугаар А/158 Хэрлэн сум

Тариаланч, ногоочдын зөвлөгөөн
зохион байгуулж, хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалт, зарцуулалтын журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засгийн газрын шинэ сэргэлтийн бодлого хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас дэвшүүлсэн зорилтыг орон нутгийн бодлоготой уялдуулан 2022 оны 4 дүгээр сарын 05-ны өдрөөс 2022 оны 4 дүгээр сарын 06-ны өдрүүдэд Тариаланч, ногоочдын зөвлөгөөнийг өргөн хүрээнд 120 хүний бүрэлдэхүүнтэйгээр 6 цагийн хугацаанд зохион байгуулах болсонтой холбогдуулан 2.400.000 (хоёр сая дөрвөн зуун мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Зардлын тооцоог хавсралтаар батлсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ц.ЧОГСОМЖАВ

231010440

Аймгийн Засаг даргын 2022 оны
...03... дугаар сарын ...05... өдрийн
...А/158... захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

| Д/д | Зардлын нэр | Нэгжийн үнэ | Тоо ширхэг | Нийт үнэ |
|---|---|---|---|---|
| 1 | Үдийн зоог | 20,000 | 120 хүн | 2,400,000 |
| Нийт үнэ | | | | 2,400,000 |